**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2016 ОНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| № | Хийх ажлын агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Улсын Их Хуралд хэлэлцэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо нөхцлөөр хангах | Яамны цахим хуудсаар хууль, бусад шийдвэрийн төслүүдийн талаар иргэдээс санал хүлээж авах, санал асуулга явуулах нөхцлийг бүрдүүлнэ | Яамны вэб сайтын хэлэлцүүлэг гэсэн цэсэн дотор Хууль, дүрэм журмын төслүүдийг байршуулж саналыг info@mm.gov.mn, nfo@mmhi.gov.mn хаягаар хүлээн авах боломжтой ба 2016 онд салбарын хэмжээнд шинээр боловсруулсан хуулийн төсөл байхгүй болно. Уул уурхайн яамны үед mm.gov.mn сайтад, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байгуулагдсанаар mmhi.gov.mn сайтад хуулийн төсөл, журамд иргэдээс саналаа өгөх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Шинээр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", "Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-аар батлуулсан. Шинээр гарсан хуулиудтай нийцүүлэн зарим журам дүрмийг шинээр боловсруулж Засгийн газраар батлуулах ажил яам, агентлагын түвшинд хийгдэж байна. 2016 онд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварын төслийг Уул уурхайн яамны үед mm.gov.mn сайтад байршуулан иргэд, ТББ-уудын төлөөл болон яамдаас Уул уурхайн сайдын албан тоотоор санал авч Засгйн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг гэрээний төслийг боловсруулах ажлын хүрээнд 2015-2016 онд яам, агентлаг, мэргэжлийн холбоод, ТББ-уудын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | төлөөллийг оролцуулсан 7 удаагийн уулзалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уул уурхай, газрын тосны салбарын хэмжээнд “Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран Улаанбаатар хот болон Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудад зохион байгуулаад байна. Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим төлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон байна. Үүний үр дүнд Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан уг хуулийн 7.1.13-т “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний загвар”-ыг Засгийн газар батлахаар заасны дагуу гэрээний загварын төслийг “Гэрээний загвар батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийн хамт боловсруулан Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br><br>Яамны цахим хуудсанд Шилэн дансны мэдээллийг байршуулж бие даасан цэстэй байна.<br>-Шилэн дансны мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой.<br>-Тодруулга өгөх албан тушаалтны нэр, холбоо барих хаягийг цахим хуудсанд байршуулсан байна. **Биелэлт 100%** |
| | | Бодлогын баримт бичгүүд болон тухайн жилд хариуцан хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад орсон хууль, УИХ-ын шийдвэрийн төсөлд холбогдох яам, агентлаг иргэд, ТББ-ын саналыг авах, хэлэлцүүлгийг ил тод нээлттэй хэлбэрээр хийх | Бодлогын баримт бичгүүд болон тухайн жилд хариуцан хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад орсон хууль, УИХ-ын шийдвэрийн төсөлд холбогдох яам, агентлаг иргэд, ТББ-ын саналыг авч, хэлэлцүүлгийг ил тод нээлттэй хэлбэрээр зохион байгуулж байгаа. Холбогдох материалуудыг хавсаргав, Цахим хуудаснаас харах боломжтой. **Биелэлт 100%** |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийгиргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх | Салбарын хэмжээнд “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна. | “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” сэдвийн хүрээнд ИРИМ хараат бус судалгааны хүрээлэнгээс хийсэн Монголын уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээний тайлангийн талаар яам, агентлагын албан хаагчид, салбарын мэргэжлийн холбоод, ТАН-эвсэл ТББ-ын төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийг Авлигатай тэмцэх газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2 удаа зохион байгуулсан. **Биелэлт 100%** |
| | | Ажилтнуудын дунд яриа танилцуулга, мэдээлэл хийх, хэвлэмэл хуудас, гарын авлага материал тараах, яамны цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах | Яамны ажилтнуудад “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт” “Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар” 2 удаагийн сургалтыг АТГ-ын Хяналт шалгалт, дүн бүртгэлийн хэлтсийн ажилтан комиссар Н.Мөнхбаяр, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Ж.Сарангэрэл нар явуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, семинарт яамны ЭБАТ болон яамны албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Сургалт семинарийн үеэр өгсөн гарын авлага материалыг яамны удирдлагуудад танилцуулж өгсөн. Долоо хоног бүрийн 5 дахь өдөр бүр нийт ажилтнуудад сургалт, мэдээллийг өгдөг. Мөн гарын авлага, тараах материалуудыг гаргаж мэдээллийн самбарыг тогтмол байршуулж байна. **Биелэлт 100%** |
| 3 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй санал солилцох | Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг яамны цахим хуудас болон<br>Able программ, мэдээллийн самбарт байрлуулж мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах. | Уул уурай, хүнд үйлдвэрийн салбартай холбоотой боловсруулсан бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг https://www.mi.gov.mn, https://www.mmhi.gov.mn цахим хуудасны “Хууль тогтоомж хэсэг болон “Able” программ дээр байршуулан ажиллаж байна. **Биелэлт 90%** |
| | | Бодлогын баримт бичгийн болон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх | Геологи, уул уурхай, газрын тос, Хүнд үйлдвэртэй холбогдох бодлогын баримт бичгийн болон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох замаар олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж яамны цахим хуудсанд байршуулсан. /https://www.mi.gov.mn/ |

| | | | |
|---|---|---|---|
| | | | https://www.mmhi.gov.mn https://www.mm.gov.mn<br>**Биелэлт 90%** |
| 4 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | Хяналт-шинжилгээ дотоод аудитын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана | ХШҮДАГ-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ТНБД-аар батлуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Яамны дотоод аудитын төлөвлөгөөний хүрээнд Уул уурхайн яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамын албан хаагч ажлын цагийн ашиглалт, цагийн бүртгэлийн байдалд хяналт, УУС-ын А/63-р тушаалаар Геологийн төв лаборатори, Геологийн судалгааны төвийн 2016 оны үйл ажиллагаанд нэгдсэн аудит хийж тайланг УУХҮЯ-ны удирдлагад танилцуулж ажилласан. Нотлох баримтуудыг хавсаргав. **Биелэлт 100%** |
| | | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон бусад тайлан мэдээг цахим хуудсанд байршуулах | Уул уурхайн яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийг 5 ангиллаар хяналтад авч нийт 268 шийдвэрийн 399 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Тогтоол шийдвэрийн биелэлт ерөнхий дүнгээр 95%-ийн биелэлттэй дүгнэж санал зөвлөмж боловсруулан 2016.01.15-ны өдрийн 1/89 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан. УУЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомжийн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй бөгөөд хэрэгжих боломжгүй болсон, мөн бүрэн хэрэгжсэн УИХ-ын тогтоолын 48 заалт, УИХ-ын байнгын хорооны тогтоолын 6 заалт, ЗГ-ын тогтоолын 54 заалт, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн 134 заалт, Ерөнхий сайдын захирамжийн 16 заалтыг хүчингүй болгуулах, хаах тухай саналыг жилийн эцсийн эрх зүйн актын тайлангийн хамт хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхайн яамны 2015 онд хэрэгжүүлсэн нийт 127 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлсэн 18 арга хэмжээний биелэлт 87,78%, толгойлон хэрэгжүүлсэн 30 арга хэмжээний биелэлт 85,33%, хамтран хэрэгжүүлсэн 79 арга хэмжээний биелэлт 83,73, нийт |

| | | | |
|---|---|---|---|
| | | | арга хэмжээний биелэлт 84,71%-ийн биелэлттэй дүгнэж санал зөвлөмж боловсруулж ажилласан.<br>Монгол Улсын Их Хурлын 2014 оны 07 сарын 01-ний өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхайн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 6 зорилт, арга хэмжээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 6 зорилт, арга хэмжээнээс 1 арга хэмжээ бүрэн биелсэн, бусад 5 арга хэмжээ хэрэгжих шатандаа 50-аас 90 хувийн биелэлттэй буюу нийт хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 81,7%-тай дүгнэж санал зөвлөмж боловсруулж ажилласан.<br>Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УУХҮЯ-ны цахим хуудасны “Ил тод байдал” гэсэн бүлэгт Хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн цэсэнд байршуулж хэрэглэгч, сонирхогч талууд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.<br>**Биелэлт 100%** |
| | | Төсвийн шууд захирагч болон яамны дотоод нэгжүүдийн менежерүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн аудитын тайлан, бусад хяналт шалгалт, ажлын хэсгийн тайлан мэдээг яамны цахим хуудас болон мэдээллийн самбараар олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар мэдээллэнэ. | УУЯ-ны төсвийн шууд захирагч, нэгжийн менежерүүдийн 2015 оны ҮДГ-ний биелэлтэд хийсэн ХШҮ-ний тайланг яамны цахим хуудасны Ил тод байдал бүлэгт тухай бүр байршуулж ажилласан.<br>УУС-ын 2015 оны 194 дүгээр тушаалаар Газрын тосны газрын 2013-2014 оны үйл ажиллагаанд аудит хийх Ажлын хэсгийг байгуулж, аудитын тайланг яамны цахим хуудсанд байршуулж олон нийт танилцах нөхцлийг бүрдүүлж ажилласан.<br>УУС, ТНБД-ын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн ажлын явц, хүрсэн үр дүнд хийсэн хяналт, үнэлгээний тайланг яамны удирдлагад танилцуулж ажилласан. **Биелэлт 100%** |
| 5 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээллэх | 2016 оны төсөв, 2015 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны жилийн төсвийн төслийг олон нийтэд тухай бүр мэдээллэж байх | 2015 оны төсвийн гүйцэтгэлийг 2016 оны 1 сарын 8-ны дотор, 2016 оны төсвийг 2015 оны 12 сарын 20 дотор, 2017 оны төсвийн төсөөллийг 2016 оны 10 сарын 15 ны дотор уул уурхайн сайдын шилэн дансанд байршуулан, яамны самбарт байршуулан ажилласан. **Биелэлт 100%** |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | | Жилийн эцсийн санхүүгийн тайланг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллэнэ. | Уул уурхайн сайдын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2016 оны 4 сарын 20-ны өдрийн дотор, 2016 оны эхний хагас жилийн нэгтгэсэн тайланг 2016 оны 8 сарын 20-ны дотор Уул уурхайн сайдын Шилэн дансанд байршуулж, яамны мэдээллийн самбарт байршуулсан. **Биелэлт 100%** |
| | | Яамны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна. | УУЯ-ны 2015 оны 12 сарын 21-ний өдрийн удирдлагын шуурхай хуралдаанаар өгсөн үүргийн дагуу УУЯ-ны 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж дүгнэлт зөвлөмж боловсруулж удирдлагад танилцуулсан. Аудитын тайланг яамны цахим хуудасны Ил тод байдал бүлэгт байршуулсан **Биелэлт 100%**. |
| | | Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд төсөвтэй холбоотой бүх мэдээллийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана. | “Шилэн дансны тухай” хуулийн дагуу яам, агентлаг, сайдын эрхлэх асуудлын хүрээний ГТЛ, ГСТ, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж /ШТШАБ/-ын шилэн дансны мэдээллийг байршуулж байгаа байдалд өдөр тутмын хяналт тавьж ажиллаж байна. ҮАГ-аас хийгдсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдэв. **Биелэлт 100%** |
| 6 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | Яам, агентлагаас олгож байгаа зөвшөөрөл / тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт , түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг яам, агентлагын цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг ил тод нээлттэй байдлыг хангана. | Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл болон Газрын тосны болон газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон журам, заавар УУЯ-ны www.mmhi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн яамны үүдний цахим дэлгэцэнд “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам”-ыг байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг тогтмол түгээж байна. Түүнчлэн 51-260631, 51-263023 дугаарын утсаар өдөр бүр тусгай зөвшөөрөлтэй холбогдсон аливаа асуултад шуурхай хариулт өгч ажиллаж байна.<br>Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх, Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал, хураамжийн хэмжээ, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 127 тоот “Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд баримтын жагсаалт |

| | | | |
|---|---|---|---|
| | | | батлах тухай” тушаалыг https://www.mi.gov.mn , https://www.mmhi.gov.mn цахим хуудаст байршуулсан. Уг журмыг шинээр боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар батлуулахаар ажиллаж байна. **Биелэлт 100%** |
| | | Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг тусгай зөвнөөрөл хүссэн иргэдэд ил тод нээлттэй байдлаар яам, агентлагын цахим хуудсанд байршуулж мэдээллэх боломжийг бүрдүүлнэ. | Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл болон Газрын тосны болон газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон журам, зааврыг УУЯ-ны www.mmhi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн яамны үүдний цахим дэлгэцэнд “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам”-ыг байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг тогтмол түгээж байна. Түүнчлэн 51-260631, 51-263023 дугаарын утсаар өдөр бүр тусгай зөвшөөрөлтэй холбогдсон аливаа асуултад шуурхай хариулт өгч ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай агуулах, ШТС-ын дүгнэлт, бүртгэлийн гэрчилгээний талаар мөн тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдийн талаар Газрын тосны газрын www.pam.gov.mn цахим хуудсанд тухай бүр шинэчлэн оруулж, нийтэд мэдээллэж байна.<br>Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байдлыг https://www.mi.gov.mn цахим хуудаст байршуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байгуулагдсанаас хойш шинээр тусгай зөвшөөрөл нэмж олгоогүй байна. **Биелэлт 100%** |
| | | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг яам, агентлагын цахим хуудсанд байрлуулна.<br>Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй Засгийн газраас | Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байдлыг https://www.mi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байгуулагдсанаас хойш шинээр тусгай зөвшөөрөл нэмж олгоогүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний холбогдох заалтыг яам, агентлагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна. | Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл болон Газрын тосны болон газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон журам, зааврыг УУЯ-ны www.mmhi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн яамны үүдний цахим дэлгэцэнд "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам"-ыг байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг тогтмол түгээж байна. Түүнчлэн 51-260631, 51-263023 дугаарын утсаар өдөр бүр тусгай зөвшөөрөлтэй холбогдсон аливаа асуултад шуурхай хариулт өгч ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай агуулах, ШТС-ын дүгнэлт, бүртгэлийн гэрчилгээний талаар мөн тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдийн талаар Газрын тосны газрын www.pam.gov.mn цахим хуудсанд тухай бүр шинэчлэн оруулж, нийтэд мэдээллэж байна. Бүтээгдэхүүнхуваах гэрээ байгуулсан байдлын талаарх судалгааг яамны цахим хуудсанд байршуулсан.<br>Холбогдох нотлох баримтуудыг хавсаргав.<br>**Биелэлт 100%** |
| 7 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | Сул ажлын байранд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтыг тухай бүр яамны цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна. | 2016 онд сул ажлын байр нийтэд зарлагдаагүй бөгөөд сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу яам болон бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчаас үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар 4 албан хаагчийн материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж дүгнэлт гаргуулан томилсон.<br>УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу Геологийн бодлогын хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын ажлын байранд томилогдох ажилтныг нөөцөөс сонгон шалгаруулж, нэр дэвшүүлж томилсон. Сонгон шалгаруулалтын материалыг яамны цахим хуудсанд хүний нөөцийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ил тод байдалд цэсэнд байршуулсан байгаа. Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын сул ажлын байранд ажилтны материалыг бүрдүүлж ТАЗ-д хүргүүлэн ТАЗ-өөс нэр дэвшүүлж санал болгосон нэр дэвшигчийн томилон ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын газрын даргын сул ажлын байранд ажилтны материалыг бүрдүүлж ТАЗ-д хүргүүлэн ТАЗ-өөс сонгон шалгаруулалтыг явуулж байна. **Биелэлт 100%** |
| 8 | Яамны албан хаагчдын Авлигаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах | Яамны 2016 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Төрийн албан хаагчдад дараах сэдвээр сургалт явуулна.<br>- Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол<br>-Төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх сургалт<br>-Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох чиглэлээр<br>-Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаар | Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр АТГ-тай хамтран 2 удаа сургалт зохион байгуулсан.<br>Яамны аппаратын чадавхийг дээшлүүлэх хүрээнд:<br>• Архив, бичиг хэргийн стандарт сэдвээр Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын дарга Б.Цэндсүрэнг урьж нийт албан хаагчдад сургалт хийсэн.<br>• Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох нь сэдвээр Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан МУИС-ын ХЗС-ийн Нийтийн эрх зүйн танхимын багш Т.Мөнх-Эрдэнийг урьж сургалт зохион байгуулсан. **Биелэлт 100%** |
| 9 | Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яамны цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарлана. | Худалдан авах ажиллагааны мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарлан ажилласан. Мэдээллийг яамны https://www.mi.gov.mn https://www.mmhi.gov.mn цахим хуудасны шилэн дансны цэсэнд "тендер" хэсэгт байршуулсан. **Биелэлт 100%** |
| | | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна. | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлтийг https://www.mi.gov.mn https://www.mmhi.gov.mn |

| | | | |
|---|---|---|---|
| | | | цахим хуудасны шилэн дансны цэсэнд байршуулсан. **Биелэлт 100%** |
| 10 | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох | Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны стратегийн хөтөлбөртэй уялдуулан Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан зааврын зарим ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн ТНБД-ын тушаалаар баталж мөрдүүлнэ. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрлөлтийн хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар баталсан ба уг тогтоол гарсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын нэгжүүдийн орон тоо, ажлын байрны жагсаалтыг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар баталсан байна. Мөн Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан зааврын Ажлын хэсэг байгуулан боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/13 дугаар тушаалаар батлан мөрдүүлж байна. байна. Тогтоол, шийдвэрүүдийн хуулбарыг хавсаргав.<br>**Биелэлт 100%** |
| | | Албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын нэгжүүдийн орон тоо, ажлын байрны жагсаалтыг баталсан Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/14 дүгээр тушаал, Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг баталсан Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/13 дугаар тушаалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны mmhi@gov.mn цахим хуудсанд Хүний нөөцийн ил тод байдал гэсэн цэсэнд байршуулсан. **Биелэлт 100%** |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Авлигтай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | Салбарын хэмжээнд авлигатай тэмцэх талаар төрийн бус байгууллагууд хамтран ажиллана. | Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах асуудлаар Уул уурхайн үндэсний ассоциаци, Монгол нүүрс ассоциаци, ТАН эвсэл ТББ-ын төлөөлөл, Авлигатай тэмцэх газар, НҮБ-тай хамтран Уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээ хийлгэн уг үнэлгээнд суурилан Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулан Уул уурхайн сайдаар батлуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. “Хил хязгааргүй алхам” ТББ, ИРИМ хараат бус судалгааны байгууллага, Нээлттэй форум нийгэмлэг, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, УУҮА, “Монгол нүүрс” ассоциацитай идэвхтэй хамтран ажиллаж байгаа болно. **Биелэлт 100%** |
| 12 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигтай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтан ажиллуулна. | Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тодорхой тусгах | Эрх бүхий албан тушаалтангаар Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Дэмчигсүрэнг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар үргэлжлүүлэн томилон ажиллуулж байна. Ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг бүрэн тусгасан болно. Тушаал, Ажлын байрны тодорхойлолтыг хавсаргав. **Биелэлт 100%** |
| | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтад тасралтгүй хамрагдах | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтуудад цаг тухай бүр нь бүрэн хамрагдсан болно.Үүнд:<br>-2016.01.07-2016.01.08-ны өдрүүдэд зохион байгуулсан Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв байгууллагын мэдүүлэг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт семинар<br>-Шударга байдлын үнэлгээ-2015 сэдэвт сургалт, семинарь ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэнтэй хамт оролцсон. **Биелэлт 100%** |
| | | Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг хадгалалт хамгаалалтыг бүрэн хангана. | Албан хаагчдын ХАСХОМ-ийг нууцийн тэмдэг дарсан дугтуйнд хийж цагаан толгойн үсгийн дараалаар жагсаалт гарган сейфэнд журмын дагуу хадгалж байна. Лац тэмдэгтэй болно. ЭБАТ нь нууцын баталгаа гаргуулсан болно. АТГ-аас ирсэн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | шалгалтаар хангалттай гэж үнэлэгдсэн болно. **Биелэлт 100%** |
| 13 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон хэрэгжүүлнэ. | Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлнэ. Санал хүсэлтийг хүлээн авч бүртгэл хөтөлж хэрэгжилтийн талаар хамт олонд тогтмол мэдээллэнэ. | Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, $32^1$ дүгээр зүйлийн $32^1$.1.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 28 дугаар зүйлийн 28.1.2-т заасны дагуу Уул уурхайн яамны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн биепэлтийг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06.1.7-ны өдрийн 3/1157 дугаар албан бичгээр АТГ-ын дэд дарга эрхэлсэн комиссар Ц.Нямдоржийн нэр дээр хүргүүлсэн. **Биелэлт 100%** |
| 14 | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулан мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулна. | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулан мэдээллийн самбар болон цахим хуудсанд ба йршуулсан. **Биелэлт 90%** |
| 15 | Яамны удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах | Уул уурхайн сайд, ТНБД, яамны удирдлагуудаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна. | Яамны удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж *https://www.mi.gov.mn* сайтын “Хууль эрх зүй” хэсэгт тогтмол байршуулсан. Сайдын тушаал болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг Уул уурхайн яамны үеийн mm.gov.mn, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны https://www.mmhi.gov.mn сайтуудад ил тод байдал бүлэгт Хүний нөөцийн ил тод байдал гэсэн цэсэнд байршуулж байна. **Биелэлт 90%** |
| | | Уул уурхайн сайд, ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаал / шийдвэр /-ыг ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаал /шийдвэр/-ыг ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлуулж байна. https://www.mmhi.gov.mn **Биелэлт 90%** |
| | | Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх журам дүрэм, зааварын ил тод нээлттэй байдлыг хангана. | Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх журам дүрэм, заврын ил тод байдлыг хангаж mm.gov.mn сайтад тогтмол байршуулж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Уул уурхайн яамнаас үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг гаргасан. Уг жагсаалтыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Цахим хуудасны мэдээллийг тухай бүр шинэчлэж байгаа. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалт, эмхтгэлийг хэвлэн гаргасан.<br>Яамны үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан.<br><br>Одоо Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсантай холбогдуулан зарим дүрэм журмыг шинэчилж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж. https://www.mmhi.gov.mn сайтад байршуулсан.<br><br>Мэдээллийг тухай бүр шинэчилж байгаа<br>**Биелэлт 100%** |
| 16 | Иргэдийн өргөдөл/санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн мэдээллийг хүлээн авч шалгах | Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх хүрээний асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэж сурталчилна. | Уул уурхай яам “Ил тод уул уурхай” хэвлэлийн бага хурлыг 1-5 сарын хооронд 5 удаа зохион байгуулж Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт арга хэмжээний хэрэгжилт болон цаг үеийн асуудлаар бүх телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээллийг өгч ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар болон геологи, уул уурхай, түлш, хүнд үйлдвэрийн салбарын талаар цаг үеийн мэдээллийг яамны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээллэж байна.<br>**Биелэлт 100%** |
| | | Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлж утас, санал авах хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс ажиллуулна. | Уул уурхайн яамны үед Угтах үйлчилгээний ажилтан ажиллуулж иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах хайрцаг, 264373 дугаарын утсыг яамны үүдний зааланд байршуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсанаар Угтах үйлчилгээний ажилтны орон тоогүй болж, ТЗУГ-ын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хариуцдаг болсон. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | **Биелэлт 90%** |
| | | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулна. | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна. **Биелэлт 70%** |
| | | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг яамны цахим хуудас болон мэдээлийн самбарт ил тод, нээлттэй байдлаар тогтмол мэдээллэнэ. | Яамны цахим хуудсанд өргөдөл, гомдолийн талаарх цонх нээн ажиллуулж, шийдвэрлэсэн байдлыг нийтэд тогтмол мэдээдэг. 2016.11.11-ний байдлаар 166 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд хэрэгжилт 81,74 хувьтай байна. **Биелэлт 70%** |
| 17 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | Тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтийг шинэчлэн гаргана. | Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар ИРИМ хараат бус судалгааны хүрээлэнгээс хийсэн Монголын уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээний судалгаа, тайланд тулгуурлан Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн гаргасан. Жагсаалтыг хавсаргав. **Биелэлт 90%** |
| | | Эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | Уул уурхайн яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм журмыг шинэчлэн баталсан.<br>Эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны судалгааг шинэчлэн гаргасан судалгааг хавсаргав. **Биелэлт 90%** |
| | | Авлигын эсрэг ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхолын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг тухай бүр зохион байгуулна. | ИРИМ хараат бус судалгааны хүрээлэнгээс хийсэн Монголын уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээний тайланд үндэслэн Уул уурхайн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар “Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөө”-г боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Ажлын хэсэг төлөвлөгөөний төслийг боловсруулж сайдад танилцуулан батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөг боловсруулахад яам, агентлаг, мэргэжлийн холбоод, “ТАН эвсэл” ТББ-ын төлөөлөл оролцсон.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тушаалаар “Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилдтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаа хэлэлцэн шийдвэрлэсэн. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шугмаар төсөл хэрэгжүүлэн төслийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу судалгаанууд болон цахим мэдээллийн ил тод байдлын хүрээнд мониторинг хийгдэж байна. Төлөвлөгөө, сайдын тушаалын хуулбар, үнэлгээний тайлан, холбогдох бусад материалыг хавсаргав. **Биелэлт 100%** |
| 18 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж биелэлтийг дурьдсан хугацаанд нь АТГ-т хүргүүлнэ. | АТГ-ын 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 02/3620 тоотоор ирүүлсэн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 3/1157 тоот албан бичгийг 24 хуудас хавсралт материалын хамт АТГ-т хүргүүлсэн. Албан тоотыг хавсаргав. **Биелэлт 100%** |
| 19 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, хүчин чармайлт | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриалгыг дэмжиж ажиллана | Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ИРИМ хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран Монголын уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээний тайлан гаргасан. Тайлангболосруулах явцад Уул уурхайн үндэсний ассоциаци, “Монгол нүүрс” ассоциаци, “ТАН эвсэл” ТББ-ын төлөөлөл, “Хил хязгааргүй алхам” ТББ, Нээлттэй нийгэм форм зэрэг ТББ-уудтай хамтран ажилласан. **Биелэлт 100%** |
| 20 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, зохион байгуулах, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх харьяа байгууллагуудад зөвлөмж өгөх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулна | Яамны албан хаагчдад Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулиар сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Харъяа агентлагууд болон яамны холбогдох албан хаагчдад шударга байдлыг талаар уулзалт хэлэлцүүлгийн 2 удаа зохион байгуулсан. **Биелэлт 100%** |
| 21 | Орон нутгийн захиргааны байгуулага, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай | Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлж, хуульд нийцүүлэн "Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээний загварыг баталж хэрэгжүүлэх | Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах |

| | | | |
|---|---|---|---|
| | зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах үйл явцад тавих хяналтыг сайжруулах | | “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварыг баталсан. **Биелэлт 100%** |
| | | Аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хуулийн хүрээнд хүнд суртал, чирэгдэлгүй, ил тод үйлчлэх ажлыг зохион байгуулах талаар тусгаж хэрэгжүүлэх | Уул уурхайн сайд Р.Жигжидийн Аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээг 2015 оны 12 дугаар сарын 18-нд зохион байгуулсан ба бүх аймгуудын Засаг дарга нарт уул уурхайн салбарын өнөөгийн байдал сэдвээр илтгэл тавьж оролцсон. Орон нутгийн захиргааны байгууллагатай байгуулах хамтран ажиллах гэрээний загварыг батласнаар аймаг, сумдууд хуулийн хүрээнд эрх ашгийн зөрчилтэй гэрээ байгуулдаг байсныг халж нэгдсэн нэг гэрээний загвартай болох юм. Гэрээний гол агуулгаас дурдвал талуудын эрх, үүрэг, орон нутгийн хөгжлийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, ил тод байдал,үйл ажиллагааг санхүүжүүлэх арга хэлбэр, гэрээний хяналтын бүтэц, гэрээний хугацаа болон дүгнэх зэрэг асуудлуудыг тусгасан байна. **Биелэлт 100%** |
| 22 | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОҮИТБС/-ыг хэрэгжүүлэгч улс орнуудад тавигдах шаардлагын хүрээнд олон нийтэд нээлттэй кадастр, лицензийн бүртгэлийн мэдээллийн сантай байх энэхүү санд ОҮИТБС-ын тайланд хамрагдсан бүх компанийн эзэмшиж буй лиценз болгоны мэдээллийг оруулах | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын шаардлагын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрөл эзэмшлийн мэдээллийг ил тод болгосон. ОҮИТБС-ын Ажлын албанаас ажиллуулдаг вэб сайт (http://eitimongolia.mn/)-аас холбогдох мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж тус бүрээр болон нэг компани хичнээн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа зэргийг оруулсан. **Биелэлт 100%** |
| | | Олборлох салбарын тендерт оролцон, хөрөнгө оруулалт хийн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг корпораци аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай, тэдний эзэмшлийн хувь хэмжээний мэдээллийг нээлттэй болгох | http://eitimongolia.mn/ цахим хуудасанд бенефициар эздийн талаар оруулсан. **Биелэлт 100%** |
| | | Ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохоор хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг нээлттэй болгох | Эрдэс баялгийн салбарын гэрээний мэдээллийн нэгдсэн санг байгуулах замаар уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт байгуулагдсан гэрээнүүдийг нийтэд ил тод болгох зорилготойгоор |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дэд ажлын хэсгийг байгуулсан. Дэд ажлын хэсгийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төрийн байгууллагатай байгуулсан гэрээг ил тод болгохоор Нээлттэй нийгэм форум ТББ-тай хамтран тусдаа вэб сайт байгуулахаар ажиллаж байна. Үүний хүрээнд Нээлттэй нийгэм форум ТББ-тай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран ажиллах Санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. **Биелэлт 100%** |
| | **Биелэлтийн хувь** | **100%-37, 90%-8, 70%-2** | **97%** |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2016 ОНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийх ажлын агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах газар нэгж, албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1 | Улсын Их Хуралд хэлэлцэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо нөхцлөөр хангах | Яамны цахим хуудсаар хууль, бусад шийдвэрийн төслүүдийн талаар иргэдээс санал хүлээж авах, санал асуулга явуулах нөхцлийг бүрдүүлнэ | 2016 он | Газар, хэлтсүүд |
| | | Бодлогын баримт бичгүүд болон тухайн жилд хариуцан хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад орсон хууль, УИХ-ын шийдвэрийн төсөлд холбогдох яам, агентлаг иргэд, ТББ-ын саналыг авах, хэлэлцүүлгийг ил тод нээлттэй хэлбэрээр хийх | 2016 он | Газар, хэлтсүүд |
| 2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийгиргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх | Салбарын хэмжээнд “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна. | 2016 оны 2-р улиралд | УУЯ<br>АМГ<br>ГТГ |
| | | Ажилтнуудын дунд яриа танилцуулга, мэдээлэл хийх, хэвлэмэл хуудас, гарын авлага материал тараах, яамны цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах | 2016 он | ТЗУГ, ЭБАТ, Цахим засаглал, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн |
| 3 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй санал солилцох | Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг яамны цахим хуудас болон Able программ, мэдээллийн самбарт байрлуулж мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах. | Байнга | ТЗУГ, ЭБАТ, Цахим засаглал, мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн |
| | | Бодлогын баримт бичгийн болон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх | Байнга | Газар хэлтсүүд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | Хяналт-шинжилгээ дотоод аудитын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана | 2016 он | ТЗУГ, ХШҮДАГ |
| | | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон бусад тайлан мэдээг цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | ТЗУГ, ХШҮДАГ |
| | | Төсвийн шууд захирагч болон яамны дотоод нэгжүүдийн менежерүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн аудитын тайлан, бусад хяналт шалгалт, ажлын хэсгийн тайлан мэдээг яамны цахим хуудас болон мэдээллийн самбараар олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар мэдээллэнэ. | Тухай бүр | ТЗУГ, ХШҮДАГ |
| 5 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээллэх | 2016 оны төсөв, 2015 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны жилийн төсвийн төслийг олон нийтэд тухай бүр мэдээллэж байх | Тухай бүр | ТЗУГ.Бодлогын газрууд, Санхүүгийн хэлтэс |
| | | Жилийн эцсийн санхүүгийн тайланг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллэнэ. | Тухай бүр | ТЗУГ, ХШҮДАГ |
| | | Яамны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна. | Тухай бүр | ТЗУГ, ХШҮДАГ |
| | | Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд төсөвтэй холбоотой бүх мэдээллийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана. | Тухай бүр | ТЗУГ, Бодлогын газрууд, Санхүүгийн хэлтэс |
| 6 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | Яам, агентлагаас олгож байгаа зөвшөөрөл / тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт , түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг яам, агентлагын цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг ил тод нээлттэй байдлыг хангана. | Тухай бүр | ТЗУГ, ТБГ, БХЗГ, ГТГ, АМГ |
| | | Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг тусгай зөвнөөрөл хүссэн иргэдэд ил тод нээлттэй байдлаар яам, агентлагын цахим хуудсанд байршуулж мэдээллэх боломжийг бүрдүүлнэ. | Тухай бүр | ТЗУГ, ТБГ, БХЗГ, ГТГ, АМГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг яам, агентлагын цахим хуудсанд байрлуулна.<br>Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй Засгийн газраас байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний холбогдох заалтыг яам, агентлагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна. | 2016 он | ТЗУГ, ТБГ, БХЗГ, ГТГ, АМГ |
| 7 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | Сул ажлын байранд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтыг тухай бүр яамны цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна. | 2016 он | ТЗУГ, ТАСЗ |
| 8 | Яамны албан хаагчдын Авлигаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах | Яамны 2016 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Төрийн албан хаагчдад дараах сэдвээр сургалт явуулна.<br>- Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол<br>-Төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх сургалт<br>-Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох чиглэлээр<br>-Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаар | 2016 оны 1-4-р улиралд | ТЗУГ |
| 9 | Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг яамны цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарлана. | Тухай бүр | ТЗУГ, Бодлогын газрууд, Санхүүгийн хэлтэс |
| | | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна. | Тухай бүр | ТЗУГ, Бодлогын газрууд, Санхүүгийн хэлтэс |
| 10 | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох | Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны стратегийн хөтөлбөртэй уялдуулан Төрийн албаны | Тухай бүр | ТЗУГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан зааврын зарим ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн ТНБД-ын тушаалаар баталж мөрдүүлнэ. | | |
| | | Албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана. | Тухай бүр | ТЗУГ |
| 11 | Авлигтай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | Салбарын хэмжээнд авлигатай тэмцэх талаар төрийн бус байгууллагууд хамтран ажиллана. | 2016 он | ТЗУГ |
| | | | | |
| 12 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигтай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтан ажиллуулна. | Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тодорхой тусгах | Тухай бүр | ТЗУГ |
| | | Авлигтай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтад тасралтгүй хамрагдах | Тухай бүр | ЭБАТ |
| | | Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг хадгалалт хамгаалалтыг бүрэн хангана. | Тухай бүр | ЭБАТ |
| 13 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон хэрэгжүүлнэ. | Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлнэ. Санал хүсэлтийг хүлээн авч бүртгэл хөтөлж хэрэгжилтийн талаар хамт олонд тогтмол мэдээллэнэ. | 2016 он | ТЗУГ, ЭБАТ |
| 14 | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулан мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулна. | 2016 он | ТЗУГ, ЭБАТ |
| 15 | Яамны удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах | Уул уурхайн сайд, ТНБД, яамны удирдлагуудаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна. | Тухай бүр | ТЗУГ, хэвлэл мэдээллийн ажилтан, мэдээлэл, технологи хариуцсан мэргэжилтэн |
| | | Уул уурхайн сайд, ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаал / шийдвэр /-ыг ил тод, нээлттэй байдлыг | Тухай бүр | ТЗУГ, хэвлэл мэдээллийн ажилтан, мэдээлэл, технологи |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна. | | хариуцсан мэргэжилтэн |
| | | Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх журам дүрэм, зааварын ил тод нээлттэй байдлыг хангана. | Тухай бүр | ТЗУГ, хэвлэл мэдээллийн ажилтан, мэдээлэл, технологи хариуцсан мэргэжилтэн |
| 16 | Иргэдийн өргөдөл/санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн мэдээллийг хүлээн авч шалгах | Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх хүрээний асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэж сурталчилна. | Тухай бүр | ТЗУГ, хэвлэл мэдээллийн ажилтан, мэдээлэл, технологи хариуцсан мэргэжилтэн |
| | | Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлж утас, санал авах хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс ажиллуулна. | 2016 он | ТЗУГ |
| | | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулна. | 2016 он | ТЗУГ |
| | | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг яамны цахим хуудас болон мэдээлийн самбарт ил тод, нээлттэй байдлаар тогтмол мэдээллэнэ. | 2016 он | ТЗУГ |
| 17 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | Тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтийг шинэчлэн гаргана. | 2016 оны 1-р улирал | ТЗУГ, ЭБАТ |
| | | Эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | 2016 оны 2-р улирал | ТЗУГ, ЭБАТ |
| | | Авлигын эсрэг ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхолын | 2016 он | ТЗУГ, ЭБАТ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг тухай бүр зохион байгуулна. | | |
| 18 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж биелэлтийг дурьдсан хугацаанд нь АТГ-т хүргүүлнэ. | Тухай бүр | ТЗУГ, ЭБАТ |
| 19 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, хүчин чармайлт | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриалгыг дэмжиж ажиллана | Тухай бүр | ТЗУГ, ЭБАТ |
| 20 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, зохион байгуулах, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх харьяа байгууллагуудад зөвлөмж өгөх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулна | 2016 он | ТЗУГ, ЭБАТ бусад газар хэлтсүүд |
| 21 | Орон нутгийн захиргааны байгуулага, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах үйл явцад тавих хяналтыг сайжруулах | Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлж, хуульд нийцүүлэн "Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээний загварыг баталж хэрэгжүүлэх | 2016 оны 2-р улирал | |
| | | Аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хуулийн хүрээнд хүнд суртал, чирэгдэлгүй, ил тод үйлчлэх ажлыг зохион байгуулах талаар тусгаж хэрэгжүүлэх | 2016 онд | ТЗУГ, БХЗГ, Бодлогын газрууд, ЭБАТ |
| 22 | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОҮИТБС/-ыг хэрэгжүүлэгч улс орнуудад тавигдах шаардлагын хүрээнд олон нийтэд нээлттэй кадастр, лицензийн бүртгэлийн мэдээллийн сантай байх энэхүү санд ОҮИТБС-ын тайланд хамрагдсан бүх компанийн эзэмшиж буй лиценз болгоны мэдээллийг оруулах | 2016 он | |
| | | Олборлох салбарын тендерт оролцон, хөрөнгө оруулалт хийн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг корпораци аж ахуйн нэгжийн нөлөө бүхий | 2016 он | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хувьцаа эзэмшигчийн тухай, тэдний эзэмшлийн хувь хэмжээний мэдээллийг нээлттэй болгох | | |
| | | Ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохоор хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг нээлттэй болгох | 2016 он | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Ж.ДЭМЧИГСҮРЭН